

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016 Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн зорилтот түвшин	6
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.2.1 Залруулсан алдаа	12
4.2.2 Төлбөрийн акт.....	12
4.2.3 Албан шаардлага	12
4.2.4 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 162
танай _____ -ны № _____ -т

“ГЭГЭЭН НУУР ЦЭВЭР УС”
ОНӨААТҮГ-ЫГ ТАТАН БУУЛГАХ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА
М.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ээлжийн амралтын нөхөн олговрыг цалинтай давхардуулсан, ажилчдын цалинг нийгмийн даатгалд дутуу тайлагнасан, санхүүгийн тайланд тооцоо нийлээгүй, 1-ээс дээш жилийн насжилттай авлага, өглөг бүртгэлтэй, татварын тодорхойлолтоор дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй, хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад газрын төлбөрийн өглөгтэй, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөөгүй хөрөнгийг акталж, данснаас хассан зэрэг 369.3 сая төгрөгийн зөрчлүүд нь Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07120444

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	158,745,637.70	100,451,253.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,662.75	451,156.39
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	300,000.00
31140	Касс арилжааны банк	0.00	300,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	27,662.75	151,156.39
31210	Төгрөг	27,662.75	151,156.39
31213	Арилжааны банк дахь харилцах	27,662.75	151,156.39
33	АВЛАГА	97,947,326.93	54,889,722.93
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,968,180.00	15,677,180.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	81,979,146.93	39,212,542.93
35	БАРАА МАТЕРИАЛ	60,770,648.02	45,110,373.74
35300	Бэлэн бүтээгдэхүүн	43,143,410.00	36,036,060.00
35400	Хангамжийн материал	17,627,238.02	9,074,313.74
35410	Бичиг хэргийн материал	627,800.00	415,800.00
35420	Аж ахуйн материал	8,886,460.00	8,113,460.00
35430	Сэлбэг хэрэгсэл	958,998.02	468,053.74
35470	Бусад хангамжийн материал	7,153,980.00	77,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	969,501,860.51	873,781,611.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	969,501,860.51	873,781,611.42
39200	Биет хөрөнгө	915,799,860.51	820,079,611.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	658,415,002.00	658,415,002.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-123,195,331.00	-149,531,931.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,982,000.00	215,982,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,542,336.31	-111,141,536.31
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	466,466,506.90	459,766,506.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-216,251,991.51	-256,177,692.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,587,479.00	11,587,479.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,661,468.57	-8,820,216.57
39300	Биет бус хөрөнгө	53,702,000.00	53,702,000.00
39301	Програм хангамж	3,100,000.00	3,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,100,000.00	-3,100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	53,702,000.00	53,702,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,128,247,498.21	974,232,864.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	123,718,978.42	141,406,079.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	123,718,978.42	141,406,079.87
41300	Өглөг	123,718,978.42	141,406,079.87
41360	Бусад өглөг	123,718,978.42	141,406,079.87
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	3,324,429.33
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	26,475,463.57	45,139,865.84
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	5,151,251.05	4,901,082.70
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	92,092,263.80	88,040,702.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,004,528,519.79	832,826,784.61
51	Засгийн газрын хувь оролцоо	1,004,528,519.79	832,826,784.61
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,740,283,615.40	1,740,283,615.40
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	53,702,000.00	53,702,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-789,457,095.61	-961,158,830.79
51210	Өмнөх үеийн үр дүн	-595,662,208.91	-789,457,095.64
51220	Тайлант үеийн үр дүн	-193,794,886.70	-171,701,735.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,128,247,498.21	974,232,864.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-44,008,745.27	46,318,917.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-239,917,836.18	-150,216,491.88
120	Нийтлэг татварын бус орлого	-239,917,836.18	-150,216,491.88
120009	Бусад орлого	3,414,862.68	0.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	80,763,049.00	101,033,809.09
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	324,095,747.86	251,250,300.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	195,909,090.91	196,535,409.36
1330	Төсвийн захирагчдаас	195,909,090.91	196,535,409.36
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	195,909,090.91	196,535,409.36
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	149,786,141.43	218,020,652.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	149,786,141.43	218,020,652.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	149,786,141.43	218,020,652.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	149,786,141.43	218,020,652.63
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	69,874,039.89	97,511,870.30
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	42,659,334.84	73,151,098.33
210813	Бусад зардал /ТӨҮГ/	37,252,766.70	47,357,684.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-193,794,886.70	-171,701,735.15
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-193,794,886.70	-171,701,735.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,793,985,615.40	-595,662,208.94	1,198,323,406.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,793,985,615.40	-595,662,208.94	1,198,323,406.46
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.03	0.03
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	-193,794,886.70	-193,794,886.70
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,793,985,615.40	-789,457,095.61	1,004,528,519.79
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,793,985,615.40	-789,457,095.61	1,004,528,519.79
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,793,985,615.40	-789,457,095.61	1,004,528,519.79
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	-0.03	-0.03
19	Тайлант үеийн үр дүн	0.00	-171,701,735.15	-171,701,735.15
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,793,985,615.40	-961,158,830.79	832,826,784.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	305,553,396.00	321,498,712.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,053,396.00	121,998,712.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,053,396.00	121,998,712.00
120009	Бусад орлого	2,029,606.00	15,132,502.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	88,023,790.00	106,866,210.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	215,500,000.00	199,500,000.00
1330	Төсвийн захирагчдаас	215,500,000.00	199,500,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	215,500,000.00	199,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,966,416.04	321,075,218.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,966,416.04	321,075,218.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,966,416.04	321,075,218.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,722,077.00	120,865,255.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	133,722,077.00	120,865,255.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,900,000.00	33,479,240.81
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	26,900,000.00	33,479,240.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	30,201,302.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	30,201,302.00
2104	Хангамж, бараа материалын зардал	118,332,500.00	104,643,446.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	42,940,000.00	39,725,050.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	75,392,500.00	64,918,396.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,011,839.04	31,885,974.55
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,748,356.07	7,101,685.55
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	26,263,482.97	24,784,289.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-1,413,020.04	423,493.64
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	1,000,000.00	0.00
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	1,000,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	1,000,000.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-413,020.04	423,493.64
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	440,682.79	27,662.75
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,662.75	451,156.39

2.5 Эдийн засгийн зорилтот түвшин

Үзүүлэлт	Тайлант оны		Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйл ажиллагааны орлого	241,500,000.0	101,033,809.09	140,466,190.9	42%
Татаас санхүүжилтийн орлого	199,500,000.0	196,535,409.36	2,964,590.6	99%
Бусад орлого	9,000,000.0		9,000,000.0	0%
ОРЛОГО	450,000,000.0	297,569,218.5	152,430,781.5	
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			-	
1.3 Нийт ашиг	450,000,000.00	297,569,218.45	152,430,781.55	66%
Бэлэн бүтээгдэхүүний зардал	121,285,000.0	81,400,434.46	39,884,565.5	67%
Ажиллагчдын цалингийн зардал	182,353,700.0	134,668,145.18	47,685,554.8	74%
ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	46,756,500.0	17,283,394.39	29,473,105.6	37%
Шуудан холбооны зардал	1,108,800.0	711,409.36	397,390.6	64%
Түрээсийн зардал	1,840,000.0	1,200,000.00	640,000.0	65%

Говь-Алтай аймгийн "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шатахууны зардал	52,383,700.0	44,200,488.00		
Аж ахуйн материалын зардал	19,325,800.0	4,719,553.00	14,606,247.0	24%
Томилолтын зардал	640,800.0	71,000.00	569,800.0	11%
Ашиглалтын зардал	30,400,000.0	21,522,512.18	8,877,487.8	71%
Сэлбэг хэрэгсэл	30,810,000.0	20,416,084.00	10,393,916.0	66%
Элэгдэл, хорогдлын зардал	115,231,400.0	95,720,248.67		
Найдваргүй авлагын зардал		47,357,684.00	(47,357,684.0)	
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	602,135,700.00	469,270,953.24	105,170,383.43	78%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	-	-	47,260,398.12	113%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-	-	47,260,398.12	113%
Татвараас чөлөөлөгдөх зардал				
Татвар төлөх ашиг алдагдал	-	-	47,260,398.12	1.13
152,135,700.00	171,701,734.79			
3.1 Орлогын татварын зардал			-	
4. Татварын дараах ашиг алдагдал	-	-	47,260,398.12	1.13
152,135,700.00	171,701,734.79			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор тус газрыг татан буулгах шийдвэрийг гаргасан тул аудитын тайлан, дүгнэлт шийдвэрийг татан буулгах комиссын даргад хүргүүлээ.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Тус газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 149.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 149.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ын зорилго нь Есөнбулаг сум, Алтай хотын иргэдийг стандарт шаардлагад нийцсэн ундны усаар хангахад оршино. Газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг ундны ус, савласан цэвэр усны үйлдвэрлэл худалдаа гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 75 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30.00	450.00	420.00
Авлага	97,950.00	54,890.00	(43,060.00)
Бараа материал	60,770.00	45,110.00	(15,660.00)
Үндсэн хөрөнгө	969,500.00	873,780.00	(95,720.00)
Нийт хөрөнгийн дүн	1,128,250.00	974,230.00	(154,010.00)
Богино хугацаат өглөг	123,720.00	141,410.00	17,690.00
Эздийн өмч	1,004,530.00	832,830.00	(171,700.00)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,128,250.00	974,230.00	(154,010.00)

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.03 сая төгрөг, банк дахь харилцах дансны үлдэгдэл 0.01 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд борлуулалтын авлага 15.7 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 31.3 сая төгрөг, байгууллагаас авах 7.9 сая төгрөг байна.

Тайлант онд хувь хүмүүсээс авах 44.7 сая төгрөгийн авлага шүүхийн шийдвэрээр хүчингүй болж данснаас хассан нь авлага буурахад голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд тооцоо нийлээгүй, нэгээс дээш жилийн насжилттай 50.3 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45.1 сая төгрөг болж 15.7 сая төгрөгөөр буурсан нь 64.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр 31.8 сая төгрөгийн цэвэр усны торхыг акталж данснаас хассан, 48.5 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр 6.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд цалингийн 3.8 сая төгрөгийн, НӨАТ-ын 38.3 сая төгрөгийн, ХХОАТ, суутгалын 6.8 сая төгрөгийн, НДШ-ийн 4.9 сая төгрөгийн, татварын алданги торгуулийн 37.2 сая төгрөгийн, бусад байгууллагад төлөх 50.3 сая төгрөгийн өр төлбөр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 68.2 сая төгрөгөөр буюу 31 хувиар нэмэгдсэн нь борлуулалт, маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цалингийн зардал, материалын зардал, элэгдлийн зардал, тээвэр шатахууны зардлуудыг хамруулсан байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 39 дугаар тушаалаар "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө

оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 450.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 602.1 сая төгрөгөөр, 152.1 сая төгрөгийн алдагдал байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 297.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 469.3 сая төгрөгийн зардал гарган, 171.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 297.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 152.4 сая төгрөг буюу 51 хувиар тасарсан нь борлуулалтын орлогыг төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 469.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 132.8 сая төгрөг буюу 22 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр алдагдал 171.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 19.6 сая төгрөгөөр илүү байгаа нь найдваргүй авлагын зардалтай холбоотой.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ны 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 19.3 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 23.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 32.6 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснээс худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлага, өглөгийн барагдуулалтыг авч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 397.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 388.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.2.1 Залруулсан алдаа

Орлого, үр дүнгийн тайланг 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй, НӨАТ-ын тайланд худалдан авалтыг 7.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, суутгагчийн хувь хүнд олгосон 12.1 сая төгрөгийн орлогыг тайлагнаагүй байсныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав.

4.2.2 Төлбөрийн акт

Ээлжийн амралтын нөхөн олговрыг цалинтай давхардуулан 0.3 сая төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3-т "ажил олгогч нь бүх ажилтныг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2-т "Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.2.3 Албан шаардлага

Зардлыг түүвэрлэн үзэхэд 19.3 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Ажилчдын 0.9 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгалд дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх," гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайланд 196.9 сая төгрөгийн тооцоо нийлээгүй, 1-ээс дээш жилийн насжилттай авлага, өглөг бүртгэлтэй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба

төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 0.2 сая төгрөгийн газрын төлбөрийн өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 164.2 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөөгүй 6.7 сая төгрөгийн 2 контейнерийг акталж данснаас хассан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ТБОНӨТХ-ийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.2.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй .

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ	8	378.4	2	9.1	1	0.3	5	369.0		
	Дүн	8	378.4	2	9.1	1	0.3	5	369.0		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ	1						1	19.3		
	Дүн	1	19.3					1	19.3		
	Нийт дүн	9	397.7	2	9.1	1	0.3	6	388.3		